



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Ахмад настнуудад хүндэтгэл
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Билгийн тооллын хаврын тэргүүн сар, Сар шинийн баярыг угтан дүүргийн ахмадуудад хүндэтгэл үзүүлсүгэй.

2.Хүндэтгэл үзүүлэх ахмад настнуудын нэрсийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 3,249,568 (Гурван сая хоёр зуун дөчин есөн мянга таван зуун жаран найм) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Хүндэтгэл үзүүлэх ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД